



**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журмыг нэгдүгээр, Хороодын нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах багийн ажиллах журмыг хоёрдугаар, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд туслах чиг үүрэг бүхий Олон нийтийн байцаагчийн ажиллах журмыг гуравдугаар, Хороодын гудамж, байранд нийтийн эргүүл ажиллуулах журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /даргын үүрэг гүйцэтгэгч О.Батмөнх/-нд үүрэг болгосугай


4. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Л.АРИУНТУЯА

1150100131
D:\2020 onl Togtool

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 08-ны
өдрийн 36 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлыг зохицуулах салбар зөвлөлийн
ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Чингэлтэй дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийн ажиллах журмын зорилго нь зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр, бүрэлдэхүүн түүний эрх үүрэг, удирдлага зохион байгуулалт, ажлын төлөвлөгөө, тайлан, санхүүжилт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль хяналтын болон төр, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгож, уг журмаар тодорхойлсон чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

1.3. Энэхүү журмын хэрэгжилтийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга зохион байгуулж, Зөвлөлийн дарга хяналт тавина.

1.4. Зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, удирдлага,
зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь дүүргийн төр захиргаа, хяналтын байгууллагын оролцоог хангасан сондгой тооны төлөөллөөс бүрдсэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх орон тооны бус зөвлөл мөн.

2.2. Зөвлөлийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга удирдах бөгөөд дэд дарга нь дүүргийн Засаг дарга, гишүүд нь тухайн нутаг дэвсгэрийн хууль хяналтын болон төр захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнууд байна.

2.3. Зөвлөлийн даргын эзгүйд түүний үүргийг дэд дарга, дэд даргын эзгүйд даргын эрх олгосноор Зөвлөлийн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

2.4. Зөвлөлд гишүүн орон гарсан тохиолдолд тухайн байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн Зөвлөлийн дарга өөрчлөлт оруулна.

2.5. Зөвлөл нь тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгаа шинжилгээ, хяналт шалгалт хийх зорилгоор ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

2.6. Зөвлөл нь орон тооны Нарийн бичгийн дарга, ажилтантай байна.

2.7. Нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж, зөвлөлийн дарга, гишүүдийг мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.

2.8. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан байх бөгөөд сард 1-ээс доошгүй удаа хуралдана.

2.9. Зөвлөлийн хуралдаанаас тогтоол гарах бөгөөд зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.10. Зөвлөл хуралдаанаараа хэлэлцсэн асуудлаар зөвлөмж, уриалга гаргаж болно.

2.11. Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг тухайн нутаг дэвсгэрт байрлан үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх үүрэгтэй.

2.12. Ажлын шаардлага, цаг үеийн асуудлаар Зөвлөлийн даргын шийдвэрээр цаг хугацааг харгалзахгүйгээр хуралдаан зарлан хуралдуулж болно.

2.13. Зөвлөл нь хуралдааныг хэлэлцэх асуудлын шинж байдлаас хамааран өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулж болно. Мөн онцгой байдлын үед цахим хэлбэрээр хуралдаж болно.

2.14. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.15. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын материалтай Зөвлөлийн дарга танилцаж, боловсруулалтын талаарх санал, дүгнэлтээ асуудал оруулагчид мэдэгдэн дахин боловсруулалт хийсний дараа хэлэлцэх асуудлыг зөвлөлийн гишүүдэд хуралдаан болохоос ажлын 1-ээс доошгүй хоногийн өмнө танилцуулна.

2.16. Зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд түүний бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно. Мөн хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаарх саналаа урьдчилан бичгээр хүргүүлж болно.

2.17. Зөвлөл нь ажлаа төлөвлөхдөө байгууллага, иргэдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлбэл зохих ажлын саналыг авч тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусган боловсруулж жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна.

2.18. Зөвлөл нь харьяа дээд шатны байгууллага, албан тушаалтнаас баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжилтийг ханган хамтран ажиллана.

2.19. Зөвлөл нь үйл ажиллагаагаа дээд шатны салбар зөвлөлд улирал, хагас, бүтэн жилээр тайлагнана.

2.20. Зөвлөлийн гишүүдийн хийж хэрэгжүүлсэн ажил, хүрсэн үр дүнг харгалзан тэдэнд урамшуулал олгож болох бөгөөд урамшууллын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон олгоно.

2.21. Зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагаанд тухайн нутаг дэвсгэрийн төр захиргаа, хууль хяналтын байгууллага, албан тушаалтнууд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

2.22. Зөвлөл нь хороодод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий баг /цаашид “Урьдчилан сэргийлэх баг” гэх/ байгуулан ажиллана.

2.23. Зөвлөл нь Урьдчилан сэргийлэх багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор санаачилсан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд холбогдох туслалцаа, дэмжлэгийг үзүүлнэ.

2.24. Зөвлөл нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Гурав. Зөвлөлийн чиг үүрэг

3.1. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах;

3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх талаар иргэд, байгууллагаас гаргасан санал, санаачилгыг судлан дэмжлэг туслалцаа үзүүлж, холбогдох байгууллага аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах;

3.4. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр зохион байгуулсан ажилд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах;

3.5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахиулах ажилд иргэд олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр байгуулагдсан Урьдчилан сэргийлэх баг, Олон нийтийн байцаагч, Нийтийн эргүүлүүдийн үйл

ажиллагаанд хяналт тавьж, заавар чиглэл өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, сургалтад хамруулах, шаардлагатай гарын авлага, материалаар хангах;

3.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж буй ажлын хүрээнд байгууллага хоорондын болон иргэдийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангаж ажиллах;

3.7. Хуульд заасан бусад чиг үүрэг

Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

4.1 Гэмт хэргээс хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн төсвийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу зарцуулна.

4.2 Зөвлөлөөс холбогдох хууль тогтоомж, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн төсвийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс санхүүжүүлнэ.

----000----

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 08-ны
өдрийн 36 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Хороодын нутаг дэвсгэрт Гэмт хэргээс урьдчилан
сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах багийн
ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Чингэлтэй дүүргийн хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий баг /цаашид "Урьдчилан сэргийлэх баг" гэх/-ийн үйл ажиллагааны чиглэл, ажлын зохион байгуулалт, гүйцэтгэл, хяналт, үр дүнг үнэлж дүгнэх, шагнаж урамшуулахтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Урьдчилан сэргийлэх баг нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хог хаягдлын тухай хууль бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр болон энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

Хоёр. Урьдчилан сэргийлэх багийн
үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Урьдчилан сэргийлэх баг нь хороо бүрт 5 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ахлагч, гишүүдээс бүрдэнэ. Урьдчилан сэргийлэх багийн бүрэлдэхүүнийг тухайн хорооны Засаг даргын саналыг үндэслэн дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл байгуулна.

2.2. Урьдчилан сэргийлэх баг нь хэлэлцсэн асуудал бүрт тэмдэглэл хөтлөн, багийн ахлагч гарын үсэг зурж баталгаажуулна.

2.3. Урьдчилан сэргийлэх баг нь хагас, бүтэн жилээр ажлаа төлөвлөн биелэлт, үр дүнг тооцон ажиллана.

2.4. Урьдчилан сэргийлэх баг нь зохион байгуулсан үйл ажиллагааныхаа тайлан мэдээг сар бүрийн 05-ны дотор нэгтгэн дүгнэж, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлнэ.

2.5. Урьдчилан сэргийлэх баг нь дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн шууд удирдлага дор үйл ажиллагаагаа явуулж, хийж гүйцэтгэсэн ажил, хүрсэн үр дүнг Зөвлөлд тайлагнана.

Гурав. Урьдчилан сэргийлэх багийн
үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг

3.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хорооны хэмжээнд удирдан зохион байгуулах, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хандсан соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулж явц, үр дүнг тооцох замаар иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлж ажиллана.

3.2. Хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хангах чиглэлээр хууль хяналтын байгууллага, иргэдтэй хамтран иргэдийн амар тайван аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

3.3. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийг татан оролцуулах ажлыг зохион байгуулна.

3.4. Хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах талаар хийж, хэрэгжүүлсэн ажлын явц, үр дүн, иргэдийн бүлэг, үүсгэл санаачлагын бүлгийн хийсэн ажлын явц, үр дүнг хэлэлцэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажилд үнэлэлт дүгнэлт өгч, саналаа дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлж ажиллана.

3.5. Нутгийн захиргааны байгууллага болон шүүх, прокурор, хууль хяналт, мэргэжлийн байгууллагуудтай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан хууль тогтоомж, улс, нийслэл, дүүргийн хэмжээнд батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийг хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдан зохион байгуулна.

3.6. Иргэдийнхээ амар тайван амьдрах нөхцөл бололцоог хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журмыг бэхжүүлэх чиглэлээр иргэд, олон нийтээс гаргасан санал, санаачлагыг дэмжиж, хамтран ажиллана.

3.7. Харьяа нутаг дэвсгэртээ олон нийт, иргэдийн оролцоотой эргүүл зохион байгуулж, удирдлагаар ханган ажиллана.

3.8. Хууль тогтоомжийг сурталчилах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

3.9. Хороодод ажиллаж буй Иргэдийн бүлэг, үүсгэл санаачлагыг дэмжих, үйл ажиллагаанд нь дэмжлэг тусалцаа үзүүлэн хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, дээд шатны байгууллагад уламжилна.

3.10. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажлын явц, үр дүнтэй танилцах, заавар, зөвлөгөө өгөх, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, хамтран ажиллана.

3.11. Шаардлагатай мэдээ, судалгааг гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлнэ.

3.12. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хангах чиглэлээр хорооны хэмжээнд шинэ санал, санаачлага гарган ажил зохион байгуулна.

3.13. Хорооны гудамж, байр бүрээс сайн дурын үндсэн дээр тухайн гудамж, байрны байнгын оршин суугч иргэнийг нийтийн эргүүлээр ажиллуулахаар сонгон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд танилцуулсанаар шийдвэр гарган, бүртгэлжүүлэн ажиллуулна.

3.14. Олон нийтийн байцаагч, нийтийн эргүүлүүдээс ирсэн дуудлага мэдээллийг “Зөрчлийн бүртгэл”-д бүртгэж, хорооны хэсгийн байцаагчид мэдээлж, шийдвэрлүүлнэ.

3.15. Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хөршийн хяналт”-ын бүлгүүдийг байгуулан, үйл ажиллагааг таниулан сурталчлан ажиллана.

Дөрөв. Урьдчилан сэргийлэх багийн эрх

4.1. Урьдчилан сэргийлэх багийн ахлагч нь багийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хуралдаан даргалах, гишүүддээ ажил үүргийг хуваарилан хариуцуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, ажлын үр дүнг тооцон ажиллах.

4.2. Нийгмийн дэг журам, хууль тогтоомжийг удаа дараа зөрчиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагад арга хэмжээ авахуулах, шийтгэл ногдуулах тухай саналыг төр захиргаа, хууль хяналт, мэргэжлийн байгууллагад хүргүүлэх.

4.3. Иргэдийн амар тайван амьдрах нөхцөл, бололцоог бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хорооны хэмжээнд тулгамдсан асуудлыг Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх.

4.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг шагнаж урамшуулах, төр засгийн шагналд уламжлах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх.

4.5. Тухайн хорооны гудамж, байрны Нийтийн эргүүл болон Олон нийтийн байцаагч нарыг мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж, холбогдох хяналтыг тавьж хамтран ажиллана.

Тав. Урьдчилан сэргийлэх багийн
ажлыг дүгнэх, түүнд урамшуулал олгох

5.1. Урьдчилан сэргийлэх багийн хийсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлт, үр дүнг харгалзан хорооны Засаг даргын үндсэн цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг Урьдчилан сэргийлэх багт олгоно.

5.2. Багт олгох урамшууллын 30 хувийг багийн ахлагчид, 70 хувийг багийн гишүүдэд ажил дүгнэсэн үзүүлэлтийн дагуу хуваарилан олгоно.

5.3. Урамшууллыг олгохдоо Урьдчилан сэргийлэх багийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайланг үндэслэн батлагдсан үзүүлэлтийн дагуу дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн шийдвэрээр олгоно.

5.4. Урьдчилан сэргийлэх багийн гишүүдийн ажлыг багийн ахлагч, багийн ахлагчийн ажлыг дүүргийн салбар зөвлөл тус тус дүгнэнэ.

5.5. Тайлан хэлэлцэх хурлаа хийгээгүй, тайлан мэдээг хугацаа хожимдуулсан, хангалтгүй ажилласан Урьдчилан сэргийлэх багийн урамшууллыг олгохгүй.

5.6. Урьдчилан сэргийлэх багийн ахлагч, гишүүдийн ажлыг дүгнэх үзүүлэлт

№	Ажил дүгнэх үзүүлэлт	Урьдчилан сэргийлэх багийн ахлагч	Гишүүн	Гишүүн	Гишүүн	Гишүүн	0-20 оноо	Тайлбар
1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, хүрсэн үр дүн	✓	✓	✓	✓	✓		
2	Урьдчилан сэргийлэх багийн үйл ажиллагаа, хүрсэн үр дүн	✓	✓	✓	✓	✓		
3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулсан байдал	✓	✓	✓	✓	✓		
4	Шинэ санаа, санаачилга болон зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан байдал	✓	✓	✓	✓	✓		
5	Өгсөн үүрэг даалгаварын биелэлт,	✓	✓	✓	✓	✓		

	тайлан мэдээ ирүүлсэн хугацаа							
	Нийт оноо							

5.7. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажилтан дээрх ажил дүгнэсэн үзүүлэлтийг нэгтгэж, орон тооны Нарийн бичгийн дарга Зөвлөлийн хуралдаанд танилцуулан урамшуулал олгох асуудлыг шийдвэрлүүлнэ.

5.8. Урьдчилан сэргийлэх багийн ахлагч болон гишүүдийн хийсэн ажлын үр дүнг харгалзан урамшууллыг үзүүлэлтийн дагуу 50-100 хувийн хооронд оноогоор дүгнэж олгоно.

91 - 100 оноо - 100%


81 - 90 оноо - 90%

61 - 80 оноо - 80%

50 - 60 оноо - 50% -ийн урамшуулал тус тус олгогдоно.

49%-иас доош оноогоор үнэлэгдсэн болон хугацаа хожимдуулсан тохиолдолд урамшуулал олгохгүй.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 29-ны
өдрийн 36 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



Олон нийтийн байцаагчийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд туслах эргүүлийн үүрэг гүйцэтгэх Олон нийтийн байцаагчийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Олон нийтийн байцаагч нь үйл ажиллагаандаа Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

1.3. Олон нийтийн байцаагч нь хорооны Урьдчилан сэргийлэх багийн ахлагчийн шууд удирдлага дор үйл ажиллагаагаа явуулах бөгөөд хорооны хэсгийн байцаагч мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

1.4. Олон нийтийн байцаагч нь тухайн хорооны нутаг дэвсгэрт 1-ээс доошгүй жил оршин суугаа, 21 нас хүрсэн, ял шийтгэлгүй, бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, эрүүл мэндийн хувьд хөдөлмөр эрхлэх бүрэн чадамжтай Монгол Улсын иргэн байна. Эрх зүйч мэргэжилтэй, цэргийн алба хаасан нь давуу байдал болно.

1.5. Хүн амын нягтрал, гэмт хэрэг, зөрчлийн гаралтын түвшинг харгалзан олон нийтийн байцаагчийн тоог дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

1.6. Олон нийтийн байцаагчаар ажиллах иргэнийг тухайн хорооны Засаг даргын саналыг үндэслэн дүүргийн Засаг даргын захирамжаар томилж, чөлөөлөх бөгөөд хорооны Засаг дарга, дүүргийн Засаг даргын Тамгын газартай гурвалсан гэрээ байгуулж ажиллана.

Хоёр. Олон нийтийн байцаагчийн үйл ажиллагааны зорилго,
үндсэн чиг үүрэг

2.1. Олон нийтийн байцаагч нь тухайн хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах, энэ чиглэлээр төр,

захиргаа, хууль хяналтын байгууллагаас хэрэгжүүлж байгаа ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлийн талаар холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх замаар иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

2.2. Олон нийтийн байцаагч нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсэгт заасан эрх, үүргийг хүлээнэ.

2.3. Журмаар тогтоосон чиг үүргээ гүйцэтгэхдээ хорооны Урьдчилан сэргийлэх баг, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, холбогдох байгууллагуудаас дэмжлэг туслалцаа авах эрхтэй болно.

Гурав. Олон нийтийн байцаагчийн үйл ажиллагааны баталгаа, урамшуулал, хориглох зүйл, хариуцлага

3.1. Олон нийтийн байцаагчид Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон энэ журамд заасан эрх, үүргийг хэрэгжүүлсний төлөө сар бүр мөнгөн урамшуулал олгох бөгөөд урамшууллын хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

3.2. Олон нийтийн байцаагч нь хийж гүйцэтгэсэн ажлаа батлагдсан ажил дүгнэх үзүүлэлтийн дагуу хорооны Урьдчилан сэргийлэх багийн ахлагчаар дүгнүүлэн сар бүрийн 05-ны дотор ажил дүгнэсэн үзүүлэлтийг тайлангийн хамт дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

3.3. Засаг даргын Тамгын газар нь Олон нийтийн байцаагчийн ажил дүгнэсэн үзүүлэлтийг нэгтгэн урамшуулал олгох асуудлыг шийдвэрнэ.

3.4. Олон нийтийн байцаагчийн мөнгөн урамшууллыг Засаг даргын Тамгын газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлаас санхүүжүүлнэ.

3.5. Олон нийтийн байцаагч нь үнэмлэх, таних тэмдэг бүхий хувцас, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай туслах хэрэгсэлтэй байна.

3.6. Олон нийтийн байцаагч нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан баталгаагаар хангагдана.

3.7. Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ эрүүл мэнд, амь насанд хохирол учирсан тохиолдолд дүүргийн Засаг даргын Тамгын газар шуурхай шийдвэрлэж, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс тусламж дэмжлэг үзүүлнэ.

3.8. Олон нийтийн байцаагч нь хүн саатуулах, тээврийн хэрэгслийг зогсоох, иргэний биед болон тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, бичиг баримтыг хурааж авах, хууль хяналтын байгууллагын нэр барих, цагдаагийн албан хаагчийн дүрэмт хувцас өмсөх, тусгай хэрэгслэл /гав, бороохой, нулимс асгаруулагч зэрэг/ ашиглах, албан

үүргийн дагуу олж авсан төрийн болон албаны, хувь хүн нууцтай холбоотой мэдээллийг бусдад болон олон нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас бусад этгээдэд өгөх, задруулахыг хориглоно.

3.9. Олон нийтийн байцаагч нь давхар албан тушаал хашихыг хориглоно.

3.10. Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн Олон нийтийн байцаагчийг үүрэгт ажлаас нь дүүргийн Засаг даргын захирамжаар чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

3.11. Олон нийтийн байцаагчийн ажил дүгнэх үзүүлэлт

№	Ажил дүгнэх үзүүлэлт	0-20 оноо	Тайлбар
1	Ажилласан цаг, цаг ашиглалтын байдал		
2	Гэмт хэрэг, зөрчлийн талаар хууль хяналтын байгууллагад мэдээлж ажилласан байдал		
3	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хангах чиглэлээр нутаг дэвсгэрт эргүүл хийсэн байдал		
4	Дүүргийн ГХУСАЗСЗ, ЗДТГ, Урьдчилан сэргийлэх багаас цаг үеийн шинжтэй үүрэг даалгаварын биелэлт, үр дүн		
5	Шинэ санаа, санаачилга гаргаж ажилласан байдал		
Нийт оноо			

3.12. Олон нийтийн байцаагчид хийсэн ажлын үр дүнг харгалзан урамшууллыг үзүүлэлтийн дагуу 100 хүртэлх оноогоор дүгнэж олгоно.

91-100 оноо 100%

81-90 оноо 90%

61-80 оноо 80%

50-60 оноо 50%-ийн урамшуулал тус тус олгогдоно.

49%-иас доош оноогоор үнэлэгдсэн болон тайлан, мэдээгээ хугацаа хожимдуулсан тохиолдолд урамшуулал олгохгүй.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 08-ны
өдрийн 36 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт



Чингэлтэй дүүргийн хороодын гудамж, байранд
Нийтийн эргүүл ажиллуулах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Иргэдийн оролцоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, иргэдийн идэвх санаачлагад суурилсан хяналтын тогтолцоог бий болгох замаар амар тайван, аюулгүй орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмаар иргэд, оршин суугчид нэгдэж, амьдарч буй орчиндоо амар тайван, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх, иргэд, хууль хяналтын байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулах, иргэдийн сайн дурын оролцоонд суурилсан гудамж байрны нийтийн эргүүл /цаашид “нийтийн эргүүл” гэх/-ийн үйл ажиллагааны чиглэл, эрх үүрэг, тэдгээрийг шагнаж урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Хороодын гудамж, байранд ажиллах нийтийн эргүүл нь Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр болон энэхүү журмыг баримтлан ажиллана.

Хоёр. Үйл ажиллагааны үндсэн зохион байгуулалт

2.1. Нийтийн эргүүл нь тухайн хорооны гудамж, байранд 1-ээс доошгүй жил оршин суугаа, 21 нас хүрсэн, эрүүл мэндийн хувьд үүрэг гүйцэтгэх чадвартай, ажил, хөдөлмөр эрхэлдэггүй иргэн байх бөгөөд сайн дурын үндсэн дээр сонгогдон ажиллана.

2.2. Урьдчилан сэргийлэх багаас шинээр эргүүл хийх нийтийн эргүүлийн анкетыг эрүүл мэндийн тодорхойлолтын хамтаар дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд танилцуулсанаар ажиллуулах эрх нь үүснэ.

2.3. Гудамж, байрны нийтийн эргүүл нь тухайн хорооны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх багийн шууд удирдлага дор ажиллах бөгөөд багаас өгсөн

үүрэг чиглэл, хуваарийн дагуу өөрийн хариуцсан гудамж, байрандаа байнгын хяналт тавьж ажиллана.

2.4. Хорооны Урьдчилан сэргийлэх баг нь гудамж, байрны нийтийн эргүүлийг шагнах тухай саналаа илтгэх хуудсаар сар бүрийн 5-ны өдрийн дотор дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлнэ.

2.5. Гудамж, байрны нийтийн эргүүлийн ажлыг тухайн хорооны Урьдчилан сэргийлэх багийн саналыг үндэслэн сар бүр 50000 /тавин мянга/ хүртэл төгрөгөөр шагнаж урамшуулна.

2.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх зүтгэл гаргасан, гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх таслан зогсооход онцгой үүрэг гүйцэтгэсэн нийтийн эргүүлийг 100000 /нэг зуун мянга/ хүртлэх мөнгөн шагналаар Урьдчилан сэргийлэх баг болон тухайн цагдаагийн хэлтсийн саналыг үндэслэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн тогтоолоор шагнаж урамшуулна.

2.7. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь нийтийн эргүүлүүдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдаж буй арга хэмжээнд татан оролцуулах, сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч удирдлагаар ханган ажиллана.

Гурав. Хороодын гудамж, байранд ажиллах
Нийтийн эргүүлийн эрх, үүрэг

3.1. Гудамж, байранд ажиллах нийтийн эргүүл нь өөрийн идэвх санаачлагаа дайчлан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, цаг үеийн асуудлыг иргэдэд шуурхай сурталчлан мэдээллэнэ.

3.2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд болон гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, бусад зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг холбогдох байгууллагад шуурхай дамжуулна.

3.3. Үйл ажиллагааныхаа чиглэлээр айл өрх, иргэд, нутаг дэвсгэрийн байгууллагуудад шаардлага тавих, асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад санал гаргана.

3.4. Нутаг дэвсгэрийнхээ иргэдийн эрүүл аюулгүй байдал, амьдрах орчин нөхцөлөө сайжруулах, гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар гудамж, байрны хуралдаанаас гарсан айл өрх, иргэдийн санал санаачлагыг хэрэгжүүлэхэд орон нутгийн Төрийн болон Төрийн бус байгууллагуудаас дэмжлэг туслалцаа хүсэх, хамтран ажиллана.

3.5. Ажлын хантаазыг эргүүл хийх хугацаанд тогтмол өмссөн байна.

Дөрөв. Үйл ажиллагааны баталгаа, хориглох зүйл,
хүлээлгэх хариуцлага

4.1. Нийтийн эргүүл нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан нийгмийн баталгааг эдэлнэ.

4.2. Нийтийн эргүүлээр ажиллах иргэний хаягийн бүртгэлийг үндэслэн тухайн гудамж, байрны Нийтийн эргүүл мөн болохыг баталсан ажлын үнэмлэхийг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс олгох бөгөөд таних тэмдэг бүхий хувцас, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай туслах хэрэгсэл, туг дарцаг хэрэглүүлж болно.

4.3. Нийтийн эргүүлийг шагнах, чадавхжуулах, сургалт зохион байгуулах, сайн туршлагыг нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилахад шаардагдах санхүүжилтийг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсвөөс санхүүжүүлнэ.

4.4. Нийтийн эргүүлүүдийг дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран жилд 1 удаа эмнэлэгийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, нарийн мэргэжлийн эмч нараар зөвлөгөө өгүүлэх ажлыг зохион байгуулна.

4.5. Журмын 4.4-т заасан шинжилгээгээр эрүүл мэндийн шаардлага хангаагүй нийтийн эргүүлийг эрхэлж буй ажлаас нь чөлөөлөх саналыг Эрүүл мэндийн төвөөс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлнэ.

4.6 Гудамж байрны нийтийн эргүүл нь давхар албан тушаал хашихыг хориглоно.

4.7. Гудамж, байранд ажиллах нийтийн эргүүл нь хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.